



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024. 08. 06 № ТНАГ-2024/13-ШТА-НА-20.
танай _____ -ны № _____ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур

018020954

болгосон.


Дүгнэлт

Ардчилсан намын Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Алтанбулаг сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр (.....³..... хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



НЭГ. ЭДИЙН ЗАСАГ-ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1.1 Алтанбулаг сумын түүхэн дурсгалт газруудыг түшиглэсэн “Түүхэн аялал жуулчлал”-ийг хөгжүүлж, сумын иргэдэд бизнесийн үйл ажиллагаа явуулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2 Алтанбулаг сумын хэмжээнд албан тушаал, ашиг сонирхлын зөрчилтэй хууль бусаар олгосон газруудыг нийтэд ил болгон хуулийн дагуу шийдвэрлүүлж, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах арга хэмжээг хуулийн дагуу ил тод зохион байгуулж, сумын мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээнэ.

1.3 “Солдат толгой”-д түүх дурсгалын цогцолбор байгуулна.

1.4 Ноос, ноолуур, малын гаралтай түүхий эдийг орон нутагтаа бэлтгэн нийлүүлэх, сүү цагаан идээ боловсруулах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулна.

1.5 Төмс, хүнсний ногоо тариаланчдыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, зоорь, хүлэмжийн аж ахуй, ногоо даршлах, савлах цех бий болгох замаар ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

ХОЁР. НИЙГЭМ-СОЁЛ УРЛАГ, СПОРТ, БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНД

2.1 Алтанбулаг сумын иргэдэд хүртээмжтэй, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, шинэ эмнэлгийн барилга барих ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллага, тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдээр уламжлуулан шийдвэрлэнэ.

2.2 Алтанбулаг сумын иргэдэд соёл урлагийг хүртээмжтэй хүргэхийн тулд , орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон шинэ Соёлын төвийн барилга барих ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллага болон тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдээр уламжлуулан шийдвэрлэнэ.

2.3 Үндэсний өв соёл, ёс заншлыг сэргээн хөгжүүлэх сурталчлан өвлүүлэх зорилгоор сумын иргэдийн дунд урлагийн наадам зохион байгуулж ардын авьяастныг тодруулан алдаршуулна.

2.4 Спортын төрлүүдээр хүүхдийн авьяасыг хөгжүүлэхэд мэргэжлийн чадварлаг багш нарыг урьж, дугуйлан, секцийг тогтмол хичээллүүлэх, улс, аймаг, олон улсын тэмцээнд оролцох тамирчдыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.5 Ерөнхий боловсролын сургуулийн орчинд стандартад нийцсэн камержуулалт суурилуулна.

2.6 Хилийн худалдаа эрхлэгчид, зорчигчдын ая тухтай байдлыг хангаж зорчих хэсэг, зам талбайн хэсэгт ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу барьж байгуулна.



ГУРАВ. АЮУЛГҮЙ ТАЙВАН ОРЧИН

3.1 Нийтийн эзэмшлийн зам талбай дахь камержуулалтыг стандартын шаардлага хангасан камераар сольж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг орон нутгийн хөрөнгөөр шат дараатай хийж хэрэгжүүлнэ.

3.2 Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулна.

3.3 Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөснөөр шаардлага хангасан ундны ус хэрэглэдэг хүн амын тоог нэмэгдүүлнэ.

3.4 “Тэрбум мод” аяны хүрээнд сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, айл өрхүүдийг хашаандаа мод тарихыг бодлогоор дэмжинэ.

3.5 Хаягдал дугуйг дахин боловсруулах цех байгуулах ажлыг бодлогоор дэмжиж, хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй хамтарч ажиллана.

3.6 Сурагчдын сургууль гэрийн хооронд аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэн, автобус явах чиглэлийг бий болгон, тогтмол явуулна.

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ

4.1 Сумын айл өрхүүдийг дулаан, цэвэр усны инженерийн шугам сүлжээнд шат дараалан холбох ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.

4.2 Сумын төвийн гудамжнуудыг сайжруулсан замаар холбох ажлыг үргэлжлүүлэн, бүрэн холбох ажлын санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

5.1 Төрөөс зохион байгуулах аливаа тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид олон нийтийн оролцоотой ил тод нээлттэй болгоно.

5.2 Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гаднын аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг орон нутгийн төсөвт оруулах эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр санал санаачилга гарган, холбогдох байгууллагад уламжилна.

5.3 “ЖИШИГ СУМ” хөтөлбөрийг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад уламжлан, идэвхжүүлнэ.


ЗУРГАА. ЗАСАГЛАЛ

6.1 Орон нутагтаа хяналттай, тэнцвэртэй, шударга, бүтээлч, бүтээгч засаглалыг бий болгоно.

6.2 Тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд иргэдийн гарын үсгийг цуглуулж сумын ИТХ хуулийн хүрээнд авч хэлэлцэх боломжийг бий болгоно.

6.3 Иргэдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн чадварлаг баг бүрдүүлж ажиллуулах талаар хамтарч ажиллана.

6.4 Нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, зах зээлд худалдан борлуулах асуудлыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.



АЛТАНБУЛАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО